

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.130

Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага	MNS 0038 : 2007 MNS 0038:2001-ын оронд
The raw cashmere. The technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь ямааны ноолуурыг бэлтгэж, хүлээн авахад хамаарна.

2. Ангилал

2.1 Ямааны ноолуурыг дараах байдлаар ангилна.

2.1.1 Өнгөөр нь:

- а/ цагаан
- б/ цагаан цайвар
- в/ цайвар
- г/ бараан

2.1.2 Чанараар нь:

- а/ дээд
- б/ I зэрэг
- в/ II зэрэг
- г/ III зэрэг гэж ангилна.

3. Техникийн шаардлага

3.1 Ямааны ноолуурын ширхэгт нь нарийн, жигд, атираа ихтэй, уян зөөлөн, өт хорхойд идэгдээгүй байна.

3.2 Ноолуураас ургамлын хог, бусад гаднын хольцыг цэвэрлэсэн байна.

3.3 Хаг, хогт хольцын хэмжээ ноолуурын нийт жингийн 10 %-иас ихгүй байна.

3.4 Савлаж багласан ноолуурын хэвийн чийглэг (12±1) % байна.

3.5 Ноолуурын өнгө 1 дүгээр хүснэгтэд заасан тодорхойлолттой тохирч байна.

1 дүгээр хүснэгт

Д/д	Өнгө	Тодорхойлолт
1	Цагаан	Ноолуур, хялгас цагаан
2	Цагаан цайвар	Ноолуур шаргал, цайвар, хялгас хул шаргал, улаан

		бор
3	Цайвар	Ноолуур хөх туяатай цайвар, хялгас цагаан хар холимог
4	Бараан	Ноолуур бараан, хялгас хар

3.6 Ноолуурын чанарын үзүүлэлт 2 дугаар хүснэгтэд заасантай тохирч байна.

2 дугаар хүснэгт

Д/д	Чанарын зэрэг	Дундаж голч, мкм	Хялгасны хэмжээ, %
1	Дээд	15,5 хүртэл	20 хүртэл
2	I	15,51-16,8	20 хүртэл
3	II	16,81-17,5	20,1-30,0
4	III	17,51-19,0	30,1-60,0

ТАЙЛБАР: 19,01–ээс 23,0 мкм-ийн дундаж голчтой ноолуурыг бүдүүн ноолуур (кашгор) гэнэ.

4. Шалгаж, хүлээн авах

4.1 Ноолуурын нийт жингийн 10 %-д чанарын шалгалтыг хийж хүлээн авна. Шаардлагатай бол 100 %-ийг хамруулан шалгалт хийнэ.

4.2 Ноолуурын чанарын талаар гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

4.3 Ямааны ноолуурын чанарыг тодорхойлохдоо дараах стандартуудыг мөрдөнө.

Үүнд:

- 1) MNS 2951:2007 Ноос, ноолуур. Шинжилгээнд дээж авах арга;
- 2) MNS 4054:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох графикайн арга;
- 3) MNS 1000:2007 Ноос, ноолуур. Бичил дурангаар нарийн тодорхойлох арга;
- 4) MNS 380:2007 Ноос, ноолуур. Чийглэг тодорхойлох арга;
- 5) MNS 1027:2007 Ноос, ноолуур. Хаг, хогт хольц тодорхойлох арга;
- 6) MNS 2949:2001 Ноосны бүрэлдэхүүн тодорхойлох арга
- 7) MNS 3961:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох, тоолох арга

5. Савлах, хадгалах

5.1 Ноолуурыг өнгө, чанараар нь ангилж, чийг, тоосноос хамгаалсан уутанд савлана.

5.2 Ноолуурыг “MNS 215:2007 Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журам”-ын дагуу савлаж, хаяглаж, хадгалж тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.